



“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК
Дархан-Уул аймаг, Дархан сум, 16-р баг,
Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ХХК,
206 тоот өрөө
Утас/факс: 7509-0044
Вэбсайт: www.dmp.mn

“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК-д шаардлагатай
шууд худалдан авалтын зар **№55**

Тендер шалгаруулалтын дугаар: **ДААТҮТӨХК/20260601647**
Төсөвт өртөг: **17,650,000 төгрөг**

2026.03.06

№	Бараа ажил, үйлчилгээний нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Үзүүлэлт
1	Инженерийн далд шугам сүлжээний засварын ажилд техник ашиглах үйлчилгээ	багц	1.0	Экскаватораар №4-5-р худаг хооронд трассын дагуух 110 м газар хөрс шороог ухуулах.

“ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР” ХХК-ний
ИНЖЕНЕРИЙН №4-5-Р ХУДАГ ХООРОНДЫН ДАЛД ШУГАМЫГ ЗАСВАРЛАХАД АШИГЛАХ
ЭКСКАВАТОРЫН АЖЛЫН ДААЛГАВАР

1.	Захиалагч байгууллага нэр, хаяг	“ДТҮ” ХХК
2.	Захиалагч байгууллагын байршил	Үйлдвэрийн бүс
3.	Захиалагчийн регистрийн дугаар:	2051303
4.	Ажлын нийт урт	1. 110 метр урттай 2.5-3 метр өргөнтэй, 3 метр гүнтэй трассын дагуух хөрс ухах. 2. 10 метр өргөнтэй 6 м урттай 2 эгнээ бүхий бетон авто замыг хуулах.
5.	Ажлын зорилго	1. 110 метрийн урттай 3 метрийн гүнтэй трассын дагуух инженерийн шугамын 2 хэсэг бүхий лоткины таг ил гаргах ажилд экскаватор ашиглан газар шорооны ажлыг хийж гүйцэтгэхэд оршино. 2. Конторын урд байрлах 10 метр өргөнтэй 6 метр урттай 2 эгнээ бетон замыг хуулан авах, буцааж анхны байрлалд оруулж бетон цутгалт хийх.

6.	Гүйцэтгэх үндсэн ажил	1. Инженерийн шугам сүлжээний №4-5-р худаг хоорондох шугамыг трассын дагуу 110 метрийн урттай, 2.5-3.0 метрийн өргөнтэй 2 хэсэг бүхий лоткинаас бүрдсэн халаалтын хос шугам, хэрэглээний хос шугам, цэвэр усны ерөнхий 1 шугам байрлах газрыг экскаватораар ухуулах. 2. Шугам хоолой лоткиг ил гаргах ажлын явцад 10м өргөнтэй бетон хучилттай 2 эгнээ бүхий 6 метр урттай авто замыг сэтэлж зам доогуурх лотки шугам хоолойг ил гаргах. 3. Шороог трассын дагуух хажуу талбайд тарааж байршуулах, лоткины таг ил гарган засвар үйлчилгээ хийх боломжийг бүрдүүлэх. 4. Засвар бүрэн дууссаны дараагаар экскаватороор трассын дагуу ухсан суваг шуудууны хажуугаар тараан байршуулсан хөрс, шороогоор дүүргэлт хийж газрын гадаргууг тэгшилнэ. 5. Ажлын явцад 10 метр өргөнтэй 6 метр урттай бетонон замыг хөрс шороо жижиг буталсан чулуугаар дүүргэлт хийж 30-50 см зузаантай цутгалт хийж анхны байдалд хэвийн болгох. 6. Дүүргэлт хийсэн суваг шуудууг хавтгай нягтруулагчаар нягтруулж хөрсийг суулгаж газрын гадаргууг тэгшлэх. 7. Нөхөн сэргээлт хийж ногоон байгууламжийг сэргээх.
----	-----------------------	---

Жич:

- Урьдчилгаа төлбөр олгохгүй
- Төлбөрийг бараа нийлүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор төлнө.

Бүрдүүлж ирүүлэх материал:

- Албан бичиг /Үнийн санал, ажил гүйцэтгэх хугацаа, төлбөрийн нөхцөлийг дурдсан байх/
- Байгууллагын гэрчилгээ, НӨАТ-ын гэрчилгээ, Татварын өргүй тухай тодорхойлолт
- Ажлын даалгавар, танилцуулга, бусад нотлох баримт
- Хариуцах этгээдийн итгэмжлэл, холбогдох мэйл, утасны дугаар

Үнийн санал хүлээн авах сүүлийн хугацаа:
2026 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 17 цаг 00 минут хүртэл

Шууд худалдан авалттай холбоотой тодруулга
болон үнийн санал хүлээн авах хаяг:
Худалдан авалтын хэлтэс
/procurement@dmp.mn/
Утас: 7509-0044